

**НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР  
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Номын сангийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд номын сангийн үйлчилгээ эрхлэх этгээд, түүний эрх үүрэг, Үндэсний номын сангийн эрх зүйн байдал, үйл ажиллагаа, номын сангийн төрөл, эрх, үүрэг, ном бүрдүүлэлт, сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, түх соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийн бүртгэлт, хадгалалт, хамгаалалт, номын сангийн уншлага үйлчилгээ, уншигч болон тусгай бүлэг уншигчийн эрх, үүргийг хангах, харилцааг зохицуулах талаар тусган боловсруулсан анхдагч хуулийн төсөл юм.

Хуулийн төсөл батлагдсанаар номын сангийн үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн, иргэдийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлж, мэдээллийн үйлчилгээг хүртээмжтэй чанартай хүргэн, иргэдийн оюуны хэрэгцээг хангах боломж, номын сангийн салбарт тулгамдаж буй асуудлыг цогцоор нь шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдэнэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ бүх шатны сургуулиудыг номын сантай байхаар заах, зохиогч болон захиалагчаас номын сангийн мэдээллийн санд заавал авах номын хувийг орон нутгийн болон төсвийн хөрөнгөөр худалдан авдаг байх нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан хувийн хэвшлээс номын сангийн салбарт хөрөнгө оруулалт хийх тохиолдолд төрөөс хэрхэн дэмжих талаар төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл номын сангийн мэргэжилтнүүдийг бэлтгэх асуудлыг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргалаа.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Номын сангийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ

